



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.НЯМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/329
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сангийн яамны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн болно. Үүнд:

- 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлээгүй, биелэлтийг үнэлэхэд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил нь тайлант онд дахин давтагдан гарсан ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна;


- Тайлант хугацаанд урсгал төсвийн /БҮТЭЗ, урсгал засвар, холбооны сувгийн түрээс/ зардлаас нийт 203.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ. Үүнд: тоног төхөөрөмж 190.2 сая, тавилга хэрэгсэл 0.4 сая, програм хангамж 13.2 сая төгрөг байна.
- Тус байгууллагын Монголбанкинд байрших улсын төсвийн ам.долларын харилцах данснаас 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Escrow incoming wire account компанируу 70.0 сая ам.долларыг Ханресурсын төлбөрт шилжүүлсэн боловч тооцоо үүсгэж, тайлагнаагүй байна. Гэвч төсвийн тодотголоор тус яамны аппаратын төсөвт төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлын ангилалд нийт 141,669.1 сая төгрөгийг баталж, 2016 оны 12 дугаар сарын 7, 22-ны өдөр нийт 141,518.2 сая төгрөгийг Ханресурсын төлбөрт гэсэн гүйлгээний утгатайгаар улсын төсвийн орлогын дансанд дамжуулан шилжүүлсэн;
- Тайлант хугацаанд олгосон гадаад томилолтын тооцоог давтан шалгахад гадаад томилолтын зардлын төсвийг гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн зардалд 267.1 сая төгрөгөөр батлуулж, гүйцэтгэлээр гадаад томилолтын буудлын зардлыг нормативаас нийт 15.7 сая төгрөгөөр илүү зарцуулсан;
- Тайлант хугацаанд төвлөрсөн арга хэмжээний бэлтгэл хангах зардлын төсвөөс нийт 957.8 сая төгрөгийн зарцуулж, ажил гүйлгээг бүртгэсэн байна. Тухайлбал: орон нутгийн хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг 158.3 сая, өмнөх Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, танилцуулга, тохимол, ТВ ролик, радио нэвтрүүлэг бэлтгүүлэх зардалд 253.2 сая, ГХЯ-ны Бээжин дэх ЭСЯ-ны автомашины паркийг шинэчлэхэд 105.7 сая, бусад зардлыг санхүүжүүлэхэд 440.6 сая төгрөгийг олгосон;
- Тус яамны ВЭБ хуудас дахь "Шилэн данс цэс"-д 2016 оны 12 дугаар сард гарсан ажил гүйлгээг байршуулсан мэдээллээс түүвэрлэн шалгахад 5.0 сая төгрөгөөс дээшхи дүнтэй нийт 610,281.8 сая төгрөгийн 58 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Эдгээр нь АОУС-250, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Хэмжилт, УСНББОУС-1, 12, Сангийн сайдын 2006 оны 388, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2013 оны 73, Төсвийн тухай хууль, УИХ-ын 2016 оны "МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 47 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Сангийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



САНГИЙН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Р.Гончигцэрэн
Аудитор: П.Чанцалдулам
Шинжээч: Д.Будмаа

Утас: 261740
gonchigtserenr@audit.gov.mn
chantsaldulamp@audit.gov.mn
budmaad@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний аудитын
газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5. Материаллаг байдал.....	6
6. Дотоод хяналт.....	7
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	7
8. Шилэн дансны мэдээлэл.....	7
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	8
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	8
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	9
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	13
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	13
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	14
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	14

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сангийн яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ/2017/42/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сангийн яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сангийн яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Нэгтгэсэн тайлангийн аудитын алба /НТАА/-ны ахлах аудитор Р.Гончигцэрэн, аудитор П.Чанцалдулам, шинжээч Д.Будмаа нар хэрэгжүүлэв.

Сангийн яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд Сангийн яамны удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, САГ/2017/42/СТА-ТШЗ

Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Төрийн үйлчилгээ” ТӨҮГ нь Засгийн газрын 2003 оны 104 дүгээр тогтоолоор байгуулагдаж, Засгийн газрын 2 дугаар байранд байрлах Төрийн 5 яамны аппаратын санхүү, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан бүртгэлийн үйл ажиллагаа, санхүү аж ахуйн болон байр ашиглалтын чиглэлийн нийтлэг үйлчилгээг хариуцан ажилладаг.

Яамдын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах байр ашиглалтын үйлчилгээ, санхүү, аж ахуйн хангалтыг хариуцан, яамдын батлагдсан төсвийн урсгал зардлын санхүүжилтийг саадгүй хийж, төрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хууль тогтоомжийн дагуу хяналт тавин ажиллаж байна.

Сангийн яам нь “Төрийн үйлчилгээ” ТӨҮГ-тай “Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоол, “Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 08 дугаар тушаалыг үндэслэн гэрээ байгуулан санхүү, аж ахуйн үйлчилгээгээ гүйцэтгүүлж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг яамны аппаратын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сангийн яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

- 2014-2016 онуудад тус яаманд урсгал зардлын санхүүжилт болон төсөл, хөтөлбөрөөс бэлтгэсэн үндсэн хөрөнгийн судалгааг гаргахад дараах байдалтай байна. Тухайлбал: Улсын төсвийн урсгал зардал болон ЗГНС-гийн санхүүжилтээр бэлтгэсэн 835.7 сая, бусад төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй хандиваар хүлээн авсан 655.6 сая, нийт 1,491.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Улсын төсөв болон төсөл, хөтөлбөрөөс бэлтгэсэн хөрөнгийн судалгаа

(сая төгрөгөөр)

Хөрөнгийн эх үүсвэр		2014 он	2015 он	2016 он	Нийт дүн
Улсын төсөв	Урсгал төсвийн санхүүжилт	221.9	401.9	203.8	827.6
ЗГНСан	ЗГНС-гийн санхүүжилт		8.1		8.1
Төсөл хөтөлбөр	Дэлхийн банк Засаглалыг дэмжих төсөл	38.8			38.8
	Тогтвортой амьжиргаа төсөл	165.5			165.5
	Дэлхийн банк Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл	60.6	193.0	33.6	287.2
	Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл		19.2		19.2
	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага-Жайка төсөл		54.4		54.4
	Дэлхийн банк ЗГ-ын гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээний систем нэмтрүүлэх төсөл		18.0		18.0
	НҮБ-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх төсөл			72.5	72.5
Нийт дүн		486.8	694.6	309.9	1,491.3

- Тайлант онд нэмэлт төсвийн дансанд Засгийн газрын 2016 оны 92 дугаар тогтоолоор “АНУ-ын Вашингтон хотод 10 дугаар сарын 3-10-ны өдрүүдэд Олон улсын валютын сан, Дэлхийн банкны 2016 оны жилийн уулзалт болон хөрөнгө оруулагчдын уулзалт зохион байгуулах зардал”-д 147.0 сая, Засгийн газрын 2016 оны 112 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчилах” зардалд 98.0 сая, Засгийн газрын 2016 оны 161 дүгээр

тогтоолоор Говь-Алтай аймаг дахь “Бургастай” хилийн боомтын шалгалтын цогцолбор, хилийн хяналтын байгууллагын ажиллагсдын орон сууцны хэвийн ажиллагааг хангах зардалд 201.1 сая, нийт 446.1 сая төгрөгийг тус бүр Засгийн газрын нөөц сангаас санхүүжилт авч, зарцуулсан байна. Засгийн газрын нөөц сангийн аудитын тайлангаар уг төсвийн зарцуулалтыг нарийвчлан үзэж болно.

- Мөн тайлант онд нэмэлт төсвийн дансанд Гадаад харилцааны яамнаас АСЕМ-ын санхүүжүүлэлтээс нийт 178.7 сая төгрөгийг шилжүүлж, гүйцэтгэлээр 174.5 сая төгрөгийг зарцуулжээ.
- 2016 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын багцад нийт 10,185.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал батлагдаж, гүйцэтгэлээр уг данснаас нийт 7,919.9 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээ хийгдсэний 7,199.6 сая төгрөг нь МУИХ-ын 2015 оны 7 дугаар тогтоол, ЗГ-ын 2015 оны 282 дугаар тогтоолын дагуу өмнөх онуудад векселээр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг өглөгөөр бүртгэсэн ажил гүйлгээний санхүүжилтийг тайлант онд олгож, шийдвэрлэсэн байна.
- Сангийн сайдын 2016 оны А/385, Төрийн нарийн бичгийн даргын Б/49 дүгээр тушаалуудаар тус яамны 3 мэргэжилтэнд нийт 100.5 сая төгрөгийг орон сууц худалдан авахад нь дэмжлэг болгон олгосноос ХХОАТ-т 10.0 сая төгрөгийг суутган харьяа Татварын хэлтэст шилжүүлж, үлдэгдэл 90.5 сая төгрөгийг хувь хүмүүст олгосон байна.
- Сангийн сайдын 2016 оны 188 дугаар тушаалаар Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгөөс нийт 30 сая төгрөгийн анхны өртөгтэй, нийт 20.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 5 ширхэг суудлын автомашиныг акталж, данснаас хасах шийдвэр гарсан байна.

“Төрийн үйлчилгээ” ТӨҮГ-аас 2013 онд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-ын дагуу Сангийн яам, УУЯ, ЭЗЯ, ХАХНХЯ-дад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлан мөрдөн ажиллаж байна.

Сангийн яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамжийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сангийн яамны аппаратын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тооцоолох компанийн “Acolous” програмыг ашиглан санхүүгийн тайланг боловсруулан гаргасан байна.

Тав. Материаллаг байдлыг тодорхойлох:

Төсвийн тухай хуулийн дагуу улсын төвлөрсөн төсвөөс санхүүждэг, 100 хувь төсөвт байгууллага тул материаллаг байдлын суурийг тооцохдоо санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар тооцоход **12,973.2** сая төгрөг байна.

Зургаа. Дотоод хяналтын талаар

Сангийн яамны өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүү, тайлан бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг “Төрийн үйлчилгээ” ТӨҮГ-ын санхүү хариуцан САГ/2017/42/СТА-ТШЗ

гүйцэтгэж, үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэлийг яамны ТЗУГ-ын мэргэжилтэн давхар хариуцаж, өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна.

Тус яамны ТНБД-ын 2016 оны А-170 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, гадаад шилжилт хөдөлгөөн, хөрөнгө актлаж устгах, худалдан борлуулах, үнэлгээ тогтоох, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж шийдвэр, дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас тус яамны аппаратын 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд аудит хийж 6 зөвлөмж өгч ажилласан бол 2015 болон 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд тухайлсан аудит хийж, зөвлөмж өгөөгүй байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төсөвт зардал 708,744.5 сая төгрөг бөгөөд тайлант хугацаанд урсгал төсвөөс 611,703.8 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 0.5 сая, нийт 611,704.3 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 611,704.3 сая төгрөгийн зарцуулалт гаргасан байна.

Төсөвт зардлын санхүүжилт болон төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг сар тутам гаргаж төсвийн ерөнхий менежер /ТНБД/-т болон ТЗУГ-т танилцуулж, зардлын хэтрэлт, хэмнэлтэд шинжилгээ хийж ажилласнаар батлагдсан төсөвт багтаан зарцуулалт гаргасан байна.

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- Тус яамны ВЭБ хуудас дахь “Шилэн данс цэс”-д 2016 оны 1-11 дүгээр сарын хооронд байршуулсан мэдээллийг Нийцлийн аудитын газраас шалгасан учраас бид 12 дугаар сарын ажил гүйлгээнээс түүвэрлэн 5.0 сая төгрөгөөс дээшхи ажил гүйлгээг “Шилэн данс” цахим хуудаст мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 610,281.8 сая төгрөгийн 58 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Завсрын аудитаар Сангийн яамны аппаратын 3 дугаар улирлын санхүүгийн тайлан болон холбогдох ажил гүйлгээнд аудит хийж, уг аудитаар илрүүлсэн асуудалд тухайлсан аудитын зөвлөмж өгөөгүй бөгөөд жилийн эцсийн аудитын дүгнэлтэд хамруулахаар тохирсон болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Тус яамны аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, Ханресурсын арбиторын шүүхийн төлбөр, сайн хувьцаа хөтөлбөр арга хэмжээ, улаан буудайн борлуулалтыг дэмжих зориулалтаар гурилын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл үзүүлсэн арилжааны банкуудад өгсөн санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардал, интернет, мэдээлэл, сувгийн үйлчилгээ, олон улсын гишүүнчлэлийн татвар, төсөл, арга хэмжээ, гадаад томилолт, шатахууны зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

- Урсгал төсвийн санхүүжилтийн харилцах данснаас тайлант онд зардлын эдийн засгийн ангилалаар гэрэл цахилгааны зардалд 90.9 сая, цахим хуудас ашиглалтын төлбөрт 33.0 сая, суваг ашигласны түрээсийн зардалд 2,472.4 сая, улсын зэрэглэл тогтоох үйлчилгээний зардалд 400.0 сая, блүүмберг мэдээллийн системийн төлбөрт 153.6 сая, хөтөлбөрт суурилсан төсвийн зардалд 1,069.8 сая, төсөл арга хэмжээний зардалд 957.8 сая, олон улсын гишүүний татварт 101.1 сая, сургалт сименарын зардалд 24.6 сая, байр ашиглалтын зардалд 252.2 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 103.2 сая, гадаад томилолтын зардал буюу гадаад харилцааг ЭЗ-лах хөтөлбөрт 183.2 сая, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын зардалд 195.5 сая төгрөгийг тус бүр шилжүүлсэн.
- Мөн уг данснаас бүтэцийн өөрчлөлтийн бусад нийтлэг- АҮТ хураамжид 2,276.2 сая, бүтцийн өөрчлөлтийн ажил олгогчоос олгох тэтгэмжид 168.4 сая, бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн ажил олгогчоос олгох тэтгэмжид 296.3 сая, улаан буудайн борлуулалтыг дэмжих зориулалтаар гурилын үйлдвэрт хөнгөлөлттэй зээл үзүүлсэн арилжааны банкуудад өгсөн санхүүжилтэнд 5,520.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.
- Тайлант хугацаанд холбооны сувгийн түрээсийн зардалд нийт 2,472.4 сая төгрөгийг төлсөн байна. Үүнээс тухайлбал Исатком ХХК-д 1,010.8 сая, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д 720.5 сая, Сангийн яам Free Balance програмын лицензийн төлбөр болон DMFAS-ын төлбөрт 443.5 сая, Грэйпсита монгол ХХК-д 25.1 сая, Топика ХХК-д 96.2 сая, Топнэт ХХК-д 33.1 сая, Саммит компьютер ХХК-д 72.2 сая, Ай ти зон ХХК-д 25.8 сая, Вертексмон ХХК-д 17.3 сая төгрөгийг тус тус төлжээ.
- Сангийн сайдын багцад нэгтгэгддэг тус яам дээр хэрэгжиж буй төслийн нэгжүүдийн байрны түрээсийн төлбөрт Монро Импекс ХХК-д 32.3 сая, Д.Ундраад 23.8 сая төгрөгийг тус бүр шилжүүлсэн байна.
- Сангийн яамны аппаратын урсгал төсвийн санхүүжилтийн харилцах данснаас 141,518.2 сая төгрөгийг Ханресурсын арбиторын шүүхийн төлбөрт, мөн 458,734.2

сая төгрөгийг сайн хувьцаа хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтэнд гэсэн гүйлгээний утгатай төлбөрийн хүсэлтээр 2016 оны 12 дугаар сард улсын төсвийн орлогын дансанд дамжуулан шилжүүлжээ.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Сангийн яамны аппаратад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Харилцах дансны нийт 621,183.6 сая төгрөгийн нийт зардлын /цалин, суутгал/-аас бусад зарлагын ажил гүйлгээний 99.4 хувь буюу 617,473.6 сая төгрөгийн ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад дараах асуудал илэрсэн болно.
 - Баримтын бүрдэл дутуу, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй 16.1 сая, бараа материалын дансанд орлого аваагүй 9.2 сая төгрөгийн тус тус ажил гүйлгээг тайлант хугацаанд бүртгэсэн;
 - Засгийн газрын цом-2016 тэмцээний бооцооны үнэ 2.0 сая, 2016 оны төсвийн төсөл батлахад хоолны зардал 1.5 сая, Амарбаясгалант хийдийн бумбаны тахилга болон бусад зардалд 4.2 сая, нийт 7.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Мөн кассын тайлангийн нийт 510.1 сая төгрөгийн ажил гүйлгээний 93.6 хувь буюу 477.6 сая төгрөгийн ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад баримтын бүрдэл дутуу, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй 20.6 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн бол Сангийн яамны газар хоорондын тэмцээний шагнал, бооцоо болон шүүгчийн зардалд 5.4 сая, тэмцээнд оролцогч тамирчидын хувцасны зардалд 2.0 сая, Амарбаясгалант хийдийн бумбаны тахилгын тавгийн идээний зардалд 1.9 сая, нийт 9.3 сая төгрөгийг зарцуулсан нь батлагдсан төсвөөс үр ашиггүй зарцуулалт хийсэн байна.

Тус байгууллагын Монголбанкинд байрших улсын төсвийн ам.долларын харилцах данснаас 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Escrow incoming wire account компанируу 70.0 сая ам.долларыг Ханресурсын төлбөрт шилжүүлсэн байна.

Гэвч 2016 оны 9 дүгээр сард хийсэн төсвийн тодотголоор төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлын ангилалд нийт 141,669.1 сая төгрөгийн төсвийг Сангийн сайдын багцад баталснаар 2016 оны 12 дугаар сарын 7, 22-ны өдөр нийт 141,518.2 сая төгрөгийг Ханресурсын төлбөрт гэсэн гүйлгээний утгатайгаар Сангийн яамны аппаратын урсгал төсвийн харилцах данснаас улсын төсвийн орлогын дансанд дамжуулан шилжүүлсэн байна.

Эдгээр нь УСНББОУС-1, 12, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “анхан шатны

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Хэмжилт-д “аж ахуй нэгж байгууллага ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого, зардлыг зөв хувиарилсан байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Касс болон харилцахад хүчин төгөлдөр анхан шатны нотлох баримтаар ажил гүйлгээг бүртгэж, баримтын бүрдүүлэлтийг хангах, тайлант хугацаанд орсон, гарсан бүх ажил гүйлгээг НББ-ийн аккурэл суурийн дагуу бүртгэлд тусгаж, бүрэн хамруулан санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаж байх талаар зөвлөмж өгөх;

2. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах зорилгоор тухайн байгууллагад бүртгэлтэй автомашинуудын шатахууны зарцуулалтын тооцооллыг дахин давтан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн болно. Тухайлбал:

- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны “жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалын дагуу шалгахад тайлант онд Сангийн сайд 0.8 сая, дэд сайд 0.2 сая, нийт 1.0 сая төгрөгийн шатахууныг хувийн автомашиндаа хийсэн;
- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д “төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчин тус байгууллагад 3000-4608см³ хөдөлгүүрийн багтаамжтай нийт 3 автомашин ашиглагдаж байна;
- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д “Бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардал төлүүлэхийг хориглоно” гэснийг зөрчин тус байгууллага нь 2500 см³, 4608см³, 5300 см³ хөдөлгүүрийн багтаамжтай 3 автомашиныг ХАА-н давхар даатгал ХХК болон төслийн нэгжээс гаргуулан ашиглаж, нийт 4.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- Дэд сайд 184 дүгээр тогтоолын 2-д “Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хот дотор ажлын хоногт дундажаар 50 км-ээс хэтрүүлэхгүй хэрэглэх” гэснийг зөрчин албан ажлын 04-41 УБҮ улсын дугаартай Соната автомашинаар хот дотор нийт 14,016 км явж, тогтоосон км нормоос 1,766 км илүү явж, нийт 2.8 сая төгрөгийн шатахууныг хэтрүүлэн зарцуулсан;

Эдгээр нь УСНББОУС-1 Ерөнхий зүйлүүд 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах естой-үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, батламж мэдэгдлийн Хэмжилт-д: “ААНБ ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого зардлыг зөв хуваарилсан байх”, ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны “жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалтай тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоол, Дэд бүтцийн сайдын 2004 оны “жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалыг тус бүр мөрдөж ажиллах, шатахууны нормыг баримтлах автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудын хувийн болон өөрийн дансанд бүртгэлгүй, харьяа байгууллагуудын автомашиныг ашиглахгүй байх мөн тухайн автомашинуудад шатахууны зарцуулалт гаргахыг таслан зогсоох талаар албан шаардлага бичих;

3. Тайлант онд Өмч хамгаалах байнгын комиссын 2016 оны 5 дугаар сарын 25-ны актлах хөрөнгийн талаар хэлэлцэх хуралдаанаар 30.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 2010-2011 онд ашиглалтанд оруулсан 20 ширхэг I Pad-ыг нэг бүрийг 20,000 төгрөгөөр худалдан борлуулах шийдвэр гаргаснаар, 7 газрын дарга, тус яамны 13 мэргэжилтэн уг хөрөнгийг худалдан авч, нийт 320,000 төгрөгийн орлогыг тушаасан бол 80,000 төгрөгийн хувь хүнээс авах авлагыг бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна.

Тайлант онд тус байгууллага нь нийт 5.0 сая төгрөгийн малын орлогыг касст бэлнээр авч, нийт 2.6 сая төгрөгийг нэмэлт төсвийн дансанд тушааж, 2.4 сая төгрөгийг касснаас бэлнээр шууд зарцуулсан байна.

Тайлант хугацаанд урсгал төсвийн /БҮТЭЗ, урсгал засвар, холбооны сувгийн түрээс/ зардлаас нийт 203.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ. Үүнд: Тоног төхөөрөмж 190.2 сая, тавилга хэрэгсэл 0.4 сая, програм хангамж 13.2 сая төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуй нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох” 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна”, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын тайлбартай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг аккрузл сууриар бүртгэх, Сангийн сайдын баталсан журмыг мөрдөж, нэмэлт төсвийн дансаар дамжуулан ажил гүйлгээг зарцуулж, бүртгэх талаар зөвлөмж өгч, мөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэх үйл ажиллагааг таслан зогсоож, хөрөнгө бэлтгэх санхүүжилтээ тухайн жилийн төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын зардлаар төсөвлөн батлуулж, зарцуулж байх талаар албан шаардлага бичих;

4. Өмнөх онд аж ахуйн материалын дансанд Спай зоне ХХК-иас 2015 оны төсвийн төсөлд суугдаагүй, батлагдаагүй нийт 27.6 сая төгрөгийн санхүү, банкны тэргүүний ажилтан тэмдэгийг гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлын ангиллаас хэвлүүлсэн бол тайлант онд Хак трейд ХХК-иас нийт 27.4 сая төгрөгийн худалдан авалт хийсний 20.4 сая төгрөг нь санхүү, банкны тэргүүний ажилтан тэмдэг, 7.0 сая төгрөг нь Сангийн яамны хүндэт тэмдэг байна. Мөн уг дансанд Мигмапринт ХХК-иас нийт 4.8 сая төгрөгийн тус яамны логотой торыг худалдан бэлтгэжээ.

Олон Улсын Хүүхдийн Найрамдал төвд тус яамны санхүүчдийн баярын арга хэмжээг тэмдэглэж нийт 6.9 сая, Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант хийдийн Бумбын тахилгад зориулан тахилгын идээ 1.9 сая, шатахуун, томилолтын зардалд 0.7 сая, нийт 2.6 сая төгрөгийг тус бүр зарцуулсан байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхээр тус байгууллагын тайлант хугацаанд олгосон гадаад томилолтын тооцоог давтан тооцоолж, шалгахад дараах асуудал илэрсэн болно.

- Гадаад томилолтын зардлын төсвийг гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрт суулгаж, нийт 267.1 сая төгрөгийн төсөв батлуулж, гүйцэтгэлээр 183.2 сая төгрөгийг зарцуулсан;
- Сангийн сайдын 2011 оны “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 188 дугаар тушаалаар зочид буудлын зардлын тооцоог тулган баталгаажуулахад бодит гүйцэтгэлээр нийт 15.7 сая төгрөгийг илүү зарцуулжээ.

Тайлант хугацаанд төвлөрсөн арга хэмжээний бэлтгэл хангах зардалд нийт 957.8 сая төгрөгийн зарцуулалтыг бүртгэсэн байна. Тухайлбал: орон нутгийн хөрөнгө оруулалтын шинжтэй санхүүжилт 158.3 сая, ЗГ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, авсан арга хэмжээг олон нийтэд сурталчилах, ЗГ-ын үйл ажиллагаа танилцуулга, тохимол, ТВ ролик, радио нэвтрүүлэг бэлтгүүлэх зардалд 198.0 сая, Шийдлийн засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн онцлог, томоохон ажлуудыг олон нийтэд сурталчилах, тайлагнах, видео нэвтрүүлэгийг цацах зардалд 55.2 сая, ГХЯ-ны Бээжин дэх ЭСЯ-ны автомашины паркийг шинэчлэх дэмжлэгт 105.7 сая, бусад зардлыг санхүүжүүлэхэд 440.6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, УИХ-ын 2016 оны “МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 47 дугаар тогтоолын холбогдох заалттай тус бүр нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг тус тус мөрдөж 2017 оны төсвийн төсөлд тусгагдсан ТАХ-ний бэлтгэл хангах зардлын тооцоог хянан, зайлшгүй хэрэгцээтэй бус төсөвт зардлыг танаж, урсгал санхүүжилтийг хэмнэх талаар зөвлөмж өгч, Сангийн сайдын 2011 оны “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 188 дугаар тушаалын дагуу шалгахад томилолтын буудлын зардал хэтэрсэн асуудалд албан шаардлага бичих;

5. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:
 - Тус яамны ВЭБ хуудас дахь “Шилэн данс цэс”-д 2016 оны 1-11 дүгээр сарын хооронд байршуулсан мэдээллийг Нийцлийн аудитын газраас шалгасан учраас бид 12 дугаар сарын ажил гүйлгээнээс түүвэрлэн 5.0 сая төгрөгөөс дээшхи ажил гүйлгээг “Шилэн данс” цахим хуудаст мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 610,281.8 сая төгрөгийн 58 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

